БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБАЯР

2024 оны 05 дугаар сарын 14 өдөр

# 72 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ХАШААНЫ АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| **1** | Төсөл боловсруулах үндэслэл | - Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 05 дугаар сарын 14-ний 06 дугаар тогтоол. |
| **2** | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | - Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, 72 дугаар цэцэрлэг |
| **3** | Зориулалт хүчин чадал | - Цэцэрлэгийн хашаа буулгаж, барих ажил |
| **4** | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно. |
| **5** | Төслийн захиалагч | - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| **6** | Төсөл гүйцэтгэх байгууллага | - Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах, гадна тохижилтын ажил гүйцэтгэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой . |
| **7** | Ажил гүйцэтгэх үе шат | - Талбайн судалгаа, хэмжилтийг илүү дэлгэрэнгүй хийх.<br>- Ашиглагчтай зөвшилцсөний дараа ажлын тоо хэмжээг захиалагчид танилцуулах.<br>- Загвар зураг боловсруулах /Нүүр хуудас батлагдаж магадлал хийгдсэн байх/.<br>- Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/.<br>- Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/. |
| **8** | Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага | - Архитектур орон зай төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй тохижилтын шийдэл гаргах.<br>**<u>Хашаа:</u>**<br>- Хашааны нийт өндөр: 2м<br>- Шон хоорондын зай: 2м |

| | | |
|---|---|---|
| | | - Шонгийн хэмжээ: 80х80 квадрат төмөр байх, зузаан 2.2мм-тэй тэнцүү болон их байх<br>- Шон хоорондын холбоосны хэмжээ: 30х50 квадрат төмөр байх, зузаан 2.0мм-тэй тэнцүү болон их байх<br>- Савх: 20х30 квадрат төмөр байх, зузаан 1.7мм-тэй тэнцүү болон их байх<br>- Сараалж хоорондын зай: 10см-ээс ихгүй байх<br>- Хашааны оройн хэсэг нь хурц, шовх үзүүргүй байх.<br>- Цэцэрлэгийн хашаанд түргэн тусламж, галын машин саадгүй нэвтрэх хаалгыг явган зорчигчийн хаалганаас тусад нь төлөвлөх<br>- Хаалганы шонг тоосгоор төлөвлөх<br>- Бетонон суурьтай, 30см өргөнтэй, хээтэй байх байх. |
| **9** | Төсөл боловсруулахад ашиглах материал | **<u>Монгол Улсын хуулиуд</u>**<br>- Хот байгуулалтын тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Газрын тухай хууль<br>- Усны тухай хууль<br>- Бусад холбогдох хууль<br>**<u>Норм, нормативууд:</u>**<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД30-01-04/<br>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбД 3.01-06-90/<br>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>- Бусад холбогдох норм, дүрэм |
| **10** | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох. |
| **11** | Онцгой нөхцөл | - Ажил эхлэх үед холбогдох хүмүүст мэдэгдэж хийгдэх ажлын дараалал, хугацааг тодорхой болгож мэдээллэнэ.<br>- Төсвийг зохиохдоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах<br>- Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх.<br>- Улаанбаатар хотын “Нэг хот, Нэг стандарт”-ын эмхэтгэл болох UCS стандартуудыг мөрдөж ажиллах.<br>- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага /UCS1101B:2022/ |

- Зураг төсвийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөвт өртөгт багтаах. Төсөвт өртөг хэтэрсэн тохиолдолд ажлын зураг батлагдахгүй болно.
- Зураг төсвийн болон ажил гүйцэтгэх явцад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг хатуу мөрдөж ажиллах.

- Эрүүл аюулгүй, чанарын шаардлага хангасан материал сонгох /БНбД-д заасан/. Зөвшөөрөгдсөн лаборатори, гарал үүслийн, сертификаттай баталгаат материалыг ашиглах.

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ЛУВСАНЖАМЪЯН

**2 ДУГААР ХОРОО, 72 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ**

